



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 4/63

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандарт, "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандарт, "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019" стандарт, "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хасэбэ интернэшил ХХК-ийн "Цэцэг" зочид буудлын 19/296, Тунамал алтан зоос ХХК-ын "Стар" зочид буудлын 19/307, Эко стар ХХК-ийн "Эко стар" зочид буудлын 19/334, Гообилэгүүд ХХК-ийн "Гэгээ" дэн буудлын 19/212, Сэргх Уул ХХК-ийн "Алтан цайз-1" дэн буудлын 19/310, Өндөр

• 1150500185

улаан трэвел ХХК-ийн “Рэдрок ресорт” амралтын газрын 19/277 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 08 сарын
07-ний өдрийн А/63 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284025 СБТ-2926 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монголия Тоёоко Инн ХХК	5939666	Тоёоко Инн Улаанбаатар	БГД-ийн 2-р хороо, Энхтайваны Өргөн чөлөө, 9Д
2	Тунамал алтан зоос ХХК	5272459	Стар	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 6-1
3	Баянгол зочид буудал ХК	2026899	Баянгол	СБД-ийн, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-5
4	Эко стар ХХК	5088275	Эко стар	БГД-ийн, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 91-4
5	РЭАБ ХХК	5496802	Говь делакс хотел энд ресорт	БЗД-ийн, 20-р хороо, Даваатын ам
6	Гоо билэгүүд ХХК	5436354	Гэгээ	БГД-ийн, 22-р хороо, Зүүннарангийн 18-р гудамж 70 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 08
дугаар сарын 07-ний өдрийн А/63
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

15284025 СБТ 48936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сэргүүл ХХК	2657112	Алтан цайз	Б3Д-ийн, 22-р хороо, Өлгийн 10-154 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 08
дугаар сарын 07-ний өдрийн А/63
дүгээр тушаалын гуравдугаар
хавсралт

5284125 СБТ 48936 1118203502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Өндөр улаан трэвел ХХК	2782111	Редрок	НД-ийн, 6-р хороо, Горхи-Тэрэлж цогцолборт газрын Өндөр улааны зүүн өвөрт
2	Элма баян уул ХХК	2021897	Баян-Уул	СХД-ийн, 24-р хороо, Баянхшууны баруун салаа
3	Тэрэлж саран трэвел ХХК	2825155	Тэрэлж саран	НД-ийн, 6-р хороо, Горхи-Тэрэлж байгалийн цогцолборт газрын Горхийн адаг
4	Моунтайн лодже ХХК	5848814	Скайлайн	НД-ийн, 6-р хороо, Горхи-Тэрэлж байгалийн цогцолборт газрын Сонгинотын адагт

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР